

**БАТЛАВ:ДЦС-4 ТӨХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

**Ү.ТӨМӨРХУЯГ**

**“ДЦС-4” ТӨХК**

**Огноо: 2020.04.28**

**ТУРБИН ЗААЛНЫ 22-29-Р БАГАНЫН ДАМ НУРУУ, ТАТАНГИЙН ХҮЧИТГЭЛ АЖИЛ ХИЙХ  
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

**Харьцуулалт/  
гэрээний дугаар:**

**АҮ-2020/47-1**

## **“ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА”**

“ДЦС-4” ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Турбин заалны 22-29-р дам нуруу, татангийн хүчитгэл хийх цахим үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системээс үнэ төлбөргүй авч болно.

Үнийн саналыг 2020 оны 05-р сарын 05-ний өдрийн 10.00 цагаас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системээр илгээнэ.

2020 оны 05-р сарын 05-ний өдрийн 10.30-д цахим системээр нээнэ. Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно

***ДЦС-4” ТӨХК ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС  
Улаанбаатар хот Баянгол дүүрэг 20-р хороо Эрчим хүчний гудамж  
Захиргааны байр 3-р давхар 311,312 тоот өрөө  
Утас:70181309, 7017-1357***

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

  - (а) Үнийн санал;
  - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь ажил гүйцэтгэх график;
  - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан сүүлийн хоёр жил компаний гэрчилгээний хуулбар
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**

7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.

7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.

7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ  
байгуулах эрх  
олгох тухай  
мэдэгдэл**


8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> <li>- Сүүлийн <b>2</b> жилийн санхүүгийн тайлан болон /аудит шаардлагагтай/;</li> <li>- Компаний гэрчилгээний хуулбар хувь</li> <li>- Сүүлийн 2 жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ гэх мэт</li> <li>- <b>Барилга угсралт 2.1.1, 2.1.2 заалтын дагуу /тусгай зөвшөөрөл/</b></li> <li>- Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай: Үүнд:  [тоног төхөөрөмжийг жагсаана]  1. Хог ачих тээврийн хэрэгсэл  2. Хөдөлмөр хамгаалалын инженер  3. Барилгын ажилчин:10 болон түүнээс дээш, категортой гагнуурчин 2, Оосорлогч, дохиочин тус бүр-2 болон түүнээс дээш  4.Ерөнхий инженер ижил төрлийн ажил хийсэн туршилга 2 жил  5.Ажил гүйцэтгэх график  6. Ачаа тээврийн машин 2 болон түүнээс дээш  7. Угсардаг шат, тавцан 20м2 цахилгаан таль /люлка/ 5ш  5.Тусгай мэргэжилтэй ажиллах хүчний нэр, регистер, мэргэжлийн үнэмлэх г м жагсаалтууд</li> <li>- Татварын тодорхойлолт  Цаасаар нэг хувь ирүүлнэ</li> </ul>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: <b>“ДЦС-4” ТӨХК Худалдан авах ажиллагааны хэлтэс</b></p> <p><b>Улаанбаатар хот Баянгол дүүрэг 20-р хороо Эрчим хүчний гудамж</b></p> <p>Давхар болон ерөөний дугаар:Захиргааны байр 3-р давхар 310, 312 тоот өрөө</p> <p>Огноо: <b>2020 оны 05-р сарын 05-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>10 цаг 00 минут</b></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер нээлт хийх газар хугацаа нь:  Байгууллагын хаяг: <b>“ДЦС-4” ТӨХК Худалдан авах ажиллагааны хэлтэс</b>  <b>Улаанбаатар хот Баянгол дүүрэг 20-р хороо Эрчим хүчний гудамж</b></p> <p>Давхар болон ерөөний дугаар: <b>Захиргааны байр 3-р давхар 310,312 тоот өрөө</b></p> <p>Огноо: <b>2020 оны 05-р сарын 05-ны өдөр</b></p>

	Цаг: <b>10 цаг 30 минут</b>
<b>ТӨӨЗ 6.2</b>	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>АҮ-2020/47-1 дугаартай Турбин заалны 22-29-р баганын дам нуруу, татангийн хүчитгэл хийх</b>

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ


  
 "ДЦС-4" ТӨХК-ийн  
 Гүйцэтгэх захирлын 2018 оны 10  
 дугаар сарын 10-ний өдрийн А/235  
 дугаар тушаалын хавсралт

Эрчим хүчний тоноглол, барилга сантехникийн засварын төсөвт ажлын жишиг тарифт цалин

Төгрөг

1.0	2,285.71	2.0	2,537.14	3.0	2,857.14	4.0	3,291.43	5.0	3,794.29	6.0	4,388.57
1.1	2,310.86	2.1	2,569.14	3.1	2,900.57	4.1	3,341.71	5.1	3,853.71		
1.2	2,336.00	2.2	2,601.14	3.2	2,944.00	4.2	3,392.00	5.2	3,913.14		
1.3	2,361.14	2.3	2,633.14	3.3	2,987.43	4.3	3,442.29	5.3	3,972.57		
1.4	2,386.29	2.4	2,665.14	3.4	3,030.86	4.4	3,492.57	5.4	4,032.00		
1.5	2,411.43	2.5	2,697.14	3.5	3,074.29	4.5	3,542.86	5.5	4,091.43		
1.6	2,436.57	2.6	2,729.14	3.6	3,117.71	4.6	3,593.14	5.6	4,150.86		
1.7	2,461.71	2.7	2,761.14	3.7	3,161.14	4.7	3,643.43	5.7	4,210.29		
1.8	2,486.86	2.8	2,793.14	3.8	3,204.57	4.8	3,693.71	5.8	4,269.71		
1.9	2,512.00	2.9	2,825.14	3.9	3,248.00	4.9	3,744.00	5.9	4,329.14		

251.43

320.00

434.29

502.86

594.29

25.14

32.00

43.43

50.29

59.43

### Тав. ЗУРАГ

Техникийн тодорхойлолтод заагдсан ажлын эзлэхүүний дагуу гаргасан график, түүнд үндэслэсэн үе шатны ажлын хуваарь, материал нийлүүлэх хуваарь ирүүлнэ. **Ажил хийх газар болон ажлын зурагтай биечлэн ирж танилцаж болно.** Ажлыг хуанлийн **90** хоногт багтаан гүйцэтгэнэ.

БАТЛАВ  
 "ДЦС-4" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
 ЗАХИРАЛ УТӨМӨР ХУЯГ

**Турбин заалны хүчитгэлийн өжил**

Д/Д	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Тайлбар
1	Хучилтын хавтгаалж, дам нуруу хүчитгэх, будахад зориулж төмөр хоолой шат угсарч буулгах	м2	90	
2	Хучилтын төмөр дам нуруу солиход зориулж түр тулгуур хийх ф133 мм	м	120	Сапуд-133мм
3	Хүчитгэх төмөр дам нурууны гадаргууг элсээр зүлгэж цэвэрлэх	м2	180	
4	Хүчитгэх төмөр дам нурууны гадаргууг сойзоор цэвэрлэх	м2	180	
5	Төмөр гадаргууг грунт хөрсжүүлэлт хийх	м2	180	
6	Төмөр дам нуруу задалж буулгах	тн	2	
7	Төмөр дам нуруу угсрах	тн	2	
8	Төмөр дам нуруу хүчитгэх 9ш	тн	1.8	Задаргааг зурагнаас үзнэ үү
9	Төмөр дам нуруу дор тэнцүүлэх ивээс хийх	тн	0.05	
10	Төмөр дам нуруу 2 удаа будах	тн	2.974	
11	Дам нуруу 2 удаа будах /туслах/	тн	6.8	
12	Төмөр татанги хүчитгэх	тн	3	Задаргааг зурагнаас үзнэ үү
13	Төмөр татанги 2 удаа будах	тн	3	
14	Хуучин бүх ган татангын гагнаасыг хүчитгэж гагнах болон татангыг баганад бэхэлсэн бэхэлгээг татангын босоо, хэвтээ холбоосуудын гагнаасыг шалгаж, гагнаасийн өндрийг ихэсгэж гагнах	тн	4.68	
15	Төмөр дам нурууг 2 удаа будах	тн	4.68	
16	Хучилтын татангыг хүчитгэх будахад зориулж төмөр хоолой шатыг угсарч	м2	183	
17	Хүчитгэх татангын гадаргууг элсээр цэвэрлэх	м2	701.82	
18	Хүчитгэх татангын гадаргууг сойзоор	м2	701.82	
19	Төмөр гадаргууг фл-озк-аар хөрсжүүлэлт	м2	701.82	
20	Хучилтын татангын шилбэ болон холбоосыг хүчитгэж засварлах	м2	7.24	Задаргааг зурагнаас үзнэ үү





21	Хучилтын татангын гэмтэлтэй шилбэ болон холбоосыг хүчитгэж засварлах	тн	0.021	
22	Ган 2 удаа будах	тн	0.021	
23	Төмөр баганын гадаргууг элсээр зүлгэж цэвэрлэх	м2	14.12	
24	Хуучин баганын гэмтэлтэй гадаргууг сойзоор зүлгэж цэвэрлэх	м2	14.12	
25	Төмөр гадаргууг фл-озк-аар хөрсжүүлэлт	м2	14.12	
26	Төмөр баганын гэмтэл засварлах	тн	0.018	
27	Багана 2 удаа будах	тн	0.018	
28	Хотойлтонд орсон хавтангийн дороос хүчитгэх будахад зориулж төмөр хоолойн	м2	96	
29	Хотойлтонд орсон хавтангийн дороос хүчитгэх, будахад зориулж түр тулгуур	м	64	
30	Хотойлтонд орсон хавтангийн дороос тулаас хийж өгч засварлах 15ш	тн	0.18	Задаргааг зурагнаас үзнэ үү
31	Тулаас тулгуур будах 2 удаа	тн	0.18	
32	Төмөр хийцийн бэлдэц бэлтгэх	тн	12.88	
33	Хуйлмал материалан дээвэр буулгах	м2	50	
34	Дулаалга буулгах 6-10см	м2	50	
35	Хучилтын төмөр хавтгаалж буулгах	м2	30	
36	Шинээр төмөр хавтгаалж угсрах	м2	30	
37	Ус тусгаарлагч хийх	м2	50	
38	Хөөсөнцөр дулаалга угсрах 6-10см	м2	50	
39	Хар цаас дээвэрт бөхлөх	м2	50	
40	Хөрсжүүлэлт хийх	м2	50	
41	Шилэн даавуу мастикаар наах	м2	50	
42	Мастикаар хөрсжүүлэлт хийх	м2	50	
43	Дээврийн орой бетондох 6-5см	м2	10	тортой
44	Акватрон шовные-оор нягтруулга хийх	м	5'	
45	Сендвичэн хаалга угсрах 6-10см	м2	100	

Тайлбар: ИЗ-ын 4-өөс

Танилцсан: НАХ-ийн дарга

Б. Төрбат

Хянасан: ТЦ-ийн дарга

Ц. Багмагнай

Эзэлхүүн гаргасан: ЗА-ны инженер

Б. Төгш-Учрал

## Зургаа. ЖИШИГ МАЯГТ

### ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

#### ***ДЦС-4 ТӨХК-н гүйцэтгэх захирал*** Ү.Төмөрхуяг танаа

1. Бид, ***[тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]***-ыг ***[тендерийн үнийг тоогоор болон үсгээр]*** төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</b>                         | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.  |
| <b>2. Төслийн менежерийн шийдвэр</b>                        | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.   |
| <b>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</b> | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.  |
| <b>4. Аюулгүй байдал</b>                                    | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.  |
| <b>5. Зааварчилгаа</b>                                      | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй  |
| <b>6. Маргааныг шийдвэрлэх</b>                              | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |
| <b>Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ</b>                    |   |
| <b>7. Ажлын хөтөлбөр</b>                                    | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.<br>7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| <b>8. Зөрчил, гологдол илрүүлэх</b>                         | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.  |
| <b>9. Зөрчил, гологдол арилгах</b>                          | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа <sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.<br>9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн   |

<sup>1</sup>Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

мэдэгдэлд

заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.

- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх** 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

## **В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ**

- 11. Үе шатны ажлын хуваарь** 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх** 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги** 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги<sup>2</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

## **Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ**

- 14. Ажил дуусгах** 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана.
- 15. Хүлээж авах** 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.

---

<sup>2</sup> Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.  
Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.  
Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
  - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
  - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;

- (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
- (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

**19. Гэрээг  
цуцалсан  
үед хийх  
төлбөр**

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

**20. Гүйцэтгэлээс  
чөлөөлөх**

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

#### Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ<sup>4</sup>

<b>ГЕН 2.1</b>	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <i>[Тендерийн урилгад заасан нэр болон дугаар]</i>
<b>ГЕН 2.1</b>	Ажил нь <i>[товч тодорхойлолт, түүний дотор төслийн хүрээнд бусад гэрээтэй холбогдох байдал]</i> -аас бүрдэнэ. Ажлын талбай нь <i>[байршил]</i> -д байрших ба зураг №...-д зааснаар тодорхойлогдсон болно.
<b>ГЕН 3.1</b>	Төслийн менежер нь <i>[томилогдсон этгээдийн нэр, хаяг]</i>
<b>ГЕН 4.1</b>	Ажил эхлэх өдөр <i>[огноо]</i> Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <i>[огноо]</i> <sup>5</sup>
<b>ГЕН 7.1</b>	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <i>[тоо]</i> хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
<b>ГЕН 9.1</b>	Чанарын баталгаат хугацаа 180 хоног байна.
<b>ГЕН 13.1</b>	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <b>0,1%</b> байна. <sup>6</sup> Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <b>30%</b> байна.
<b>ГЕН 17.1</b>	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг <i>[огноо]</i> -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг <i>[огноо]</i> -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ <i>[мөнгөн дүн]</i> байна.
<b>ГЕН 19.1</b>	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын <i>[хувь]</i> -р тооцно.



## ГЭРЭЭНИЙ МАЯГТ

### ЗАХИАЛАГЧ

### ГҮЙЦЭТГЭГЧ

\_\_\_\_\_ (Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_ (Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_ (Гарын үсэг)

\_\_\_\_\_ (Гарын үсэг)

\_\_\_\_\_ (Албан тушаал)

\_\_\_\_\_ (Албан тушаал)

### **[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_ хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай / \_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана, \_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_

оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Ажлын явц, далд ажлын зургууд хавсаргах
- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

#### **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*

*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*

*[Утас/факсын дугаар]*

*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

#### **ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*Албан тушаал, нэр]*

*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*Гүйцэтгэгчийн хаяг*

*[Утас/факсын дугаар]*

*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

